



**BPN**  
Business Professionals Network

Монголын үйлдвэрлэлийн хөгжлийн төлөө



**BPN Монгол**





ВРН Монгол  
салбарын захирал:

Маркус Эппэр

*Бидэнд ямар нэг зүйл өөрчлөх боломж байгаа бол түүнийг одоо байгаа байдлаа засахад биш, харин урагшлахад ашиглах хэрэгтэй.*

## ХЯМРАЛЫН ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?


Дэлхий нийтээрээ бид хямралд орсон байна. Хямрал хэзээ дуусах вэ? Эдийн засгийн уналт нүүрлэх үү? Хэн ч юу болохыг таашгүй. Хүмүүс амьдралдаа үргэлж тэнцвэрт байдалд байхыг зорьдог.

Бид өдөр тутмын амьдралаа хөнгөвчлөхийн тулд олон янзын дадлуудыг өөрсдөдөө хэвшүүлдэг. Бидний дадал зуршил ямар нэг хямралаас болж (Ж нь. Корона вирус) саатахад бид стресстэй бухимддаг. Бага хэмжээний стресс (эерэг стресс=ашигтай стресс) биднийг үр бүтээлтэй болгодог.

Богино хугацаанд бүтээмж нэмэгдэнэ. Харин стресс хэт их болбол эсвэл хэт удаан үргэлжилбэл юу болох вэ (сөрөг стресс=гамшиг, гай зовлон)? Тэр үед бид уналтад орно. Хэр гүн унах вэ? Бид тэнцвэрээ эргэн олох тэр мөч хүртэл. «Хамгийн доод» уналтын цэгт хүрсэн үед бидэнд **3** боломж бий.

- Тэндээ гацах (хамгийн муу хувилбар);
- Алдсан тэнцвэрт байдлаа эргүүлэн олж авахыг оролдох;
- Хямралын өмнө байснаасаа өндөрт хүрэхийн тулд чадваруудаа хөгжүүлэх (шинийг бүтээх; өөрийгөө өөр өнцгөөс харах гэх мэт).

## Хямралын давуу тал юу вэ?



Бид үтэр түргэн өмнөх байдалдаа очихыг эрмэлздэг. Гэхдээ бидэнд ямар нэг зүйл өөрчлөх боломж байгаа бол түүнийг одоо байгаа байдлаа засахад биш, харин урагшлахад ашиглах хэрэгтэй.

Та өвлийн цэцэрлэгийг дотроо төсөөлнө үү: Гурван хана нь битүү шил, харин дөрөв дэх хана нь нээлттэй байна.

Газраар битүү үхсэн зөгийнүүд байна. Гэвч газарт нэг ч үхсэн хэдгэнэ алга, хэдий тэд эргэн тойронд чинь дүнгэнэлдэж байгаа ч.

Яагаад зөвхөн зөгийнүүд үхсэн гэж бодож байна? Тэд нэг л шилэн ханыг нэвтлэн гарах гэж хэдэн цагаар хичээгээд, бүр сүүлдээ ямар ч хүч тамиргүй болж газар унан үхэцгээсэн. Харин хэдгэнүүд зөгийнүүдээс өөр байсан.

Тэд ч бас шилэн ханыг нэвтлэх гэж үзсэн. Гэхдээ тэд бүх шилэн ханануудыг ээлжлэн туршсаар гарах гарцаа олсон.

Та өөрийгөө аль нь гэж бодож байна? Та зөгий юу эсвэл хэдгэнэ үү?

Хямрал бидэнд урьд урьдынхаас илүү хөгжих боломжийг олгодог. Бид өөрсдийн нөлөөллийн хүрээг урьд нь бодож байснаас илүү том гэдгийг олж хардаг.

Туршлагаас харахад хямрал бүрийн дараа сэргэлт болдог.

Шөнө бүрийн дараа өдөр болдог. Та урагш хараарай. Хямрал асуудал биш, харин бид хэрхэн хариу үйлдэл үзүүлэх нь асуудал юм!

**ВРН**-ийн нэрийн өмнөөс та бүхэнд ирж буй **2021** онд эрүүл энх байж, амжилтад хүрэхийг хүсье!

## Business Recovery



## БИЗНЕС АКАДЕМИ

Орчин үеийн дэвшилтэт технологийн тусламжтайгаар дэлхийн хаанаас ч, хэзээ ч, хүссэн үедээ сурч мэдэн өөрийгөө хөгжүүлэх боломжтой бөгөөд бид ч бас Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

**BPN**-ийн “Бизнес Академи” нь бизнес эрхлэгчдэд Швейцарын системчилсэн арга зүйгээр бизнесийн удирдлагын мэдлэг олгох сургалтуудыг санал болгодог бөгөөд бид үүссэн нөхцөл байдалд тохируулан сургалтуудаа онлайн хэлбэрт шилжүүлэн ажиллаж байгаа билээ.

Энэ хүрээнд бизнес эрхлэгчдийг сэдэлжүүлэх, урам зоригжуулах богино хэмжээний вэбинар сургалтуудыг шинээр хөтөлбөртөө оруулан, амжилттай зохион байгууллаа. Мөн “Байгууллагын алсын хараа” болон “Байгууллагын ёс зүй” сэдэвт сургалтуудаа бид байгууллага хамт олон болон хөтөлбөрийн оролцогчдоо тусгайлан санал болгодог бөгөөд уг сургалтуудад хамтын ажиллагааны хүрээнд Хаан банкны “Жижиг Дунд Бизнес Эрхлэгчдийг Дэмжих” төвийн бизнес эрхлэгчид, “Магна профит энд инвестмент” ББСБ, мөн “ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ” ХК зэрэг байгууллагууд хамрагдлаа.

Түүнчлэн бид “Цагийн менежмент”, “Зах зээлд чиглэсэн компанийн удирдлага” сургалтуудаа **HYBRID** буюу хосолсон хэлбэрээр анх удаа зохион байгуулсан нь бизнес эрхлэгчдэд сонирхолтой, шинэлэг байсан бөгөөд **HYBRID** сургалтын онцлог нь танхимаар болон онлайнаар сургалтад оролцох орчин үеийн арга зүй юм.

Ирэх **2021** онд бид Швейцар экспертүүдээс гадна дотоодын чадварлаг сургагч багш нартай хамтран бизнес эрхлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцэхүйц, цаг үеэ мэдэрсэн сургалтуудыг санал болгон ажиллах болно.

Эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй эрхэм баялаг бүтээгч та бүхэнтэй хамтран ажиллахдаа **BPN**-ийн зүгээс зүгэлж таатай байх болно.



BPN-ийн сургалт хариуцсан зохицуулагч:

Ц.Дуламрагчаа





## ВРN-ийн хөтөлбөрийн хүрээнд 2021 онд зохиогдох сургалтууд:

**Бизнесийн удирдлага**

**Санхүүгийн менежмент**

**Маркетинг**

**Хамт олноо удирдах**

**Цагийн менежмент**

**Төслийн менежмент**

**Зөрчлийн менежмент**

**Зах зээлд чиглэсэн компанийн удирдлага**

**Байгууллагын алсын хараа**

**Байгууллагын ёс зүй**

**Хамт олноо урам зоригжуулах (Вебинар)**

**Хямралын үеийн удирдлага (Вебинар)**

**Хөрвөх чадварын төлөвлөгөө (Вебинар)**

**Workshop: (сард нэг удаа)**

**Бизнес төлөвлөгөө**

**Санхүүгийн төлөвлөгөө**





ВРН-ийн  
Бизнес кoүч:

Х.Ундармаа

## EMERGENCY FUND

**ВРН** байгууллагын авч хэрэгжүүлсэн **"COVID-19"** цар тахлын үеийн санхүүгийн хөнгөлөлттэй дэмжлэг нь хөтөлбөрийн оролцогчдод хямралыг даван туулахад чиглэгдсэн бодлого билээ. Тодорхой шалгуур хангасан хөтөлбөрийн оролцогчид маань энэхүү хөнгөлөлттэй зээлийн тусламжтайгаар үүсээд байсан асуудлуудаа тодорхой хэмжээнд шийдвэрлэх боломжтой болсонд **ВРН** -ийн зүгээс баяртай байна.

### Хөтөлбөрийн оролцогчдын сэтгэгдлээс:

**"БАТБАЙГАЛЬ"** ХХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Ч.ЦЭГМИД

Та бүхнээс авсан зээлийн санхүүжилт бидний хувьд **"COVID-19"** цар тахлын үед цаг үеэ олсон дэмжлэг болж өгсөнд бид та бүхэнд маш их талархаж байна.

**"COVID-19"** цар тахлын дотоодын халдвар бүртгэгдэж **"Гамшгийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн"** хорио цээрийн энэ үед бүтээгдэхүүн хүргэлтийн ажлыг хийхэд та бүхний өгсөн хөнгөлөлттэй зээлээр худалдан авсан **"Nissan Vanette"** маркийн 2 автомашиныг хүргэлтийн үйлчилгээнд явуулснаар захилгын борлуулалт нэмэгдсэн. Ингэснээр хэрэглэгчид гэрээсээ бүтээгдэхүүнээ захиалан авч УОК-ийн гэрээсээ гарахгүй байх шийдвэрийг биелүүлэхэд бид өөрсдийн зүгээс хувь нэмэр оруулж ажиллаа.

Биднийг дэмжин ажиллаж байдаг **"ВРН Mongolia"**-ийн хамт олон та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье.







“ТАБИТА” ХХК-ийн  
Ерөнхий захирал

**Г.Гантунгалаг**



Манай компани зах зээл дээр шинэ брэнд үүсгэн өмнө нь худалдаалагдаж байгаагүй эрүүл мэндийн талх үйлдвэрлэн борлуулж эхэлсэн бөгөөд хэрэглэгчдэд сайн танигдаагүйн улмаас борлуулалт багатай, буцаалт ихтэй, сар бүр алдагдалтай ажиллаж байлаа.

Гэсэн хэдий ч бид энэ бүх алдагдлыг өөр дээрээ үүрэн компаниа хөл дээр нь босгох гэж хичээж явах үед маань

---

**ВРН-ийхэн бидэнд хөнгөлөлттэй санхүүгийн дэмжлэг авах боломж олгосон.**


---

Энэхүү хүүгүй зээлийг зах зээл дээр бүтээгдэхүүнээ таниулах үйл ажиллагаандаа зарцуулан маркетингийн идэвхжүүлэлт хийж эхэлсэн.

Үүний үр дүнд ес, арав, арван нэгэн саруудад алдагдалгүй ажилласан бөгөөд улмаар ашигтай ажиллаж эхлээд байгаа билээ.

Удахгүй бидний тооцоолсон хэмжээнд хүртэл ашигтай ажиллаж чадна гэдэгтэй итгэлтэй байна.

Хамтран ажилладаг **ВРН**-ийн хамт олондоо баярлалаа.





ВРN-ийн  
Бизнес көүч:

### С.Цэндсүрэн

*Бизнес эрхлэгчдэдээ хамгийн хэрэгтэй үед нь цаг алдалгүй тусалж дэмжихээр онлайн көүчинг үйлчилгээ үзүүлж байна.*

## БИЗНЕС КӨУЧИНГ ҮЙЛЧИЛГЭЭ

Өнөөдөр дэлхий дахинаа тулгарч буй цар тахлын нөлөөгөөр үүссэн эдийн засгийн хямрал нь хувь хүний хандлага, хэрэгцээнд маш ихээр нөлөөлж байна. Энэ нь бизнес эрхлэгчдийн хувьд бизнес модель, тэр дундаа маркетинг, борлуулалтын процесстoo томоохон өөрчлөлт хийх сорилттой тулгарлаа. Зах зээлийн хумигдмал, таагүй орчинд хэрэглэгчдийн урьд өмнөхөөс илүү шалгууртай болж байгаа хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэх том сорилттой тулгараад байгаа бизнес эрхлэгчдэдээ **ВРN** байгууллага бизнес зөвлөгөө болон көүчинг үйлчилгээг үзүүлж байна.

Манай байгууллага **2020** онд өөрсдийн үйл ажиллагааны үндсэн **4** чиглэлийн нэг болох бизнес көүчинг үйлчилгээндээ урьд онуудаас илүү төвлөрч ажилласан. Тухайлбал монгол салбарын баг хамт олон Англи улсын Лондон хотод төвтэй **“Creative Metier“** компанийн **“Business Focused Executive Coaching”** сургалтад хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн. Манай швейцар экспертүүд болон монгол бизнес көүчүүд **ВРN**-ийн хөтөлбөрийн оролцогчдодоо биечлэн көүчинг өгөхөөс гадна одоогийн хорио цээрийн үед онлайнаар мөн көүчинг өгч байна. Ингэснээр бид хөтөлбөрийн оролцогчдодоо хамгийн хэрэгтэй үед нь цаг алдалгүй тусалж дэмжиж байна.

Ирж буй **2021** оноос эхлэн бид **ВРN**-ийн хөтөлбөрийн оролцогчдоос гадна бусад бизнес эрхлэгчдэд ч мөн бизнес зөвлөгөө болон көүчинг үйлчилгээгээ санал болгох болно. Иймд бизнес эрхлэгч та бүхэн корона вирусийн цар тахлаас улбаатай хатуу хөл хорионы үед ч бидэнтэй холбогдон онлайн көүчинг авах боломжтой.







**BPN** -ийн хөтөлбөрийн  
оролцогч **DEW**  
брэндийн  
үүсгэн байгуулагч

## **Л.Зул**

**Dew** буюу **Шуудэр** брэнд нь **2017** онд үүсгэн байгуулагдсан бөгөөд **100%** торгон дээр зориулалтын будгаар гараар зурж дахин давтагдашгүй, гоёмсог бүтээлүүдийг урладаг онцлогтой. Мэргэжлийн баг хамт олонтой хамтарч жилд **3-4** коллекцийг цуглуулга бүтээлүүдийг зураг авалт хийж танилцуулдаг бөгөөд тухайн коллекцийн дагуу захиалагч тус бүрийн биед тааруулан захиалга аван **4** дэх жилдээ амжилттай үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Брэндийн үүсгэн байгуулагч **Зул** миний бие урлагийн сургууль төгсөж мөн Герман улсад мэргэжил дээшлүүлсэн бөгөөд үйл ажиллагаа эрхэлж байх явцад бизнесийн мэдлэг, чадвар алхам тутамд дутагдаж байсан юм.

**2020** оны **7** сараас **BPN**-ийн хөтөлбөрийн **2** удаагийн **Workshop**-д хамрагдсанаар урд өмнө нь сонсож байгаагүй боловч яг эрхэлж буй бизнест минь тохирсон хэрэгтэй мэдээллүүдийг олж авснаар **BPN**-ий хөтөлбөрийн оролцогч болохоор шийдсэн билээ. **BPN** хөтөлбөрт хамрагдсанаар “Зах зээлд чиглэсэн компани удирдлага”, “Цагийн менежмент”, “Хамт олноо урам зоригжуулах” сэдэвт сургалтуудад хамрагдсан бөгөөд тухайн сургалтуудад хамрагдсанаар эрхэлж буй бизнесээс гадна хувь хүний хөгжилд минь маш их ахиц, дэвшил гарч байгааг дуулгахад таатай байна. Мөн **BPN**-ий найрсаг хамт олон хөтөлбөрийн оролцогчдынхоо ажлын байранд зочлон, тухайн салбар бүрт нь тохирсон зөвлөгөөг хүргэж, онол практик хослуулан оролцогч нэг бүртэй илүү ойр дотно харилцдаг нь жижиг дунд бизнес эрхлэгч бид бүгдэд алдаж болохгүй алтан боломж юм.

Хөтөлбөрийн оролцогч болсноор **6** удаагийн үнэ төлбөргүй көучинг үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон бөгөөд цар тахлаас улбаатай энэ хүнд хэцүү цаг үед тохирсон, хэрэгжүүлж болохуйц үнэтэй зөвлөгөө өгч байгаа нь хямралыг давж туулан бизнесээ аварч үлдэх цаашлаад бизнесээ хэрхэн амжилттайгаар удирдах үйл явцад минь маш их тус нэмэр болж байгаа. Мөн цаашлаад алсын хараагаа хэрхэн зөв тодорхойлж түүндээ ямар арга замаар хүрэх, санхүүгээ хэрхэн сахилга баттайгаар удирдах, бизнестээ хөрөнгө оруулах гэх мэт маш олон үнэ цэнтэй мэдээллүүдийг ойлгомжтой, сонирхолтой, таатай мөн зөв системтэйгээр сургалт, семинар зохион байгуулан бизнес эрхлэгч бид бүгдэд хүргэдэг **BPN**-ий найрсаг хамт олон болон Швейцар экспертүүддээ маш их талархаж буйгаа илэрхийлье.

## ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУЛАХ ЦЭГ



ВРN-ийн ахмад  
эксперт

Маркус Крамэр

*Зөв үгс нь аливаа  
зүйлийг хөдөлгөх  
буюу эхлүүлэх,  
аюултай эсвэл  
найдваргүй  
байдлыг бууруулах,  
нийгмийн эв  
нэгдлийг  
нэмэгдүүлэх,  
тайван байдлыг бий  
болгох, тэр бүү хэл  
эдийн засгийг ч  
өсгөх чадвартай.*



"Хямралын үед хамгийн зоримоогоор хийсэн алхам ихэнхдээ хамгийн аюулгүй зам байдаг." Др. Хенри Киссингер, Америкийн улс төрч, дипломатч, зөвлөх.

Манай гаригийн чиглүүлэгч цэг бол Алтангадас од гэдгийг бүгд мэднэ. Үдэш бүрийгээс үүр цайх хүртэл нэг л газраа бидний найдвартай ар тал болон гялтганан байдаг алтан гадас од. Үүний адил бизнесүүд, брэндүүд, баг хамт олон хүнд хэцүү цаг үеийг амжилттай даван туулахын тулд юунд чиглэн ажиллаж, юуг анхаарах ёстой вэ?

Энгийнээр хэлэхэд та машин жолоодон явахдаа хаашаа явж байгаагаа сайн мэдэж байдаг буюу хүрэх зорилгоо тодорхой мэдэж байдаг. Санамсаргүй буруу эргэлт хийлээ гэхэд навигацийн систем даруй хариу үйлдэл үзүүлж чиглэлийг дахин тооцоолно. Энэ нь **GPS** систем шууд унтран шинээр замыг тооцоолохгүй харин зорилгодоо аль болох хурдан хүрэх боломжит хувилбарыг үргэлжлүүлэн тооцоолно гэсэн үг юм.

Он цагийн туршид ухаалаг харилцаа нь бүх л төрлийн хямралын үед гол үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Хүмүүс хоорондын болон олон нийтийн харилцааны аль алинд нь зөв үгсийг ашиглах нь хямралын үед онцгой чухал байдаг. Үг нь өөрчлөлт хийх хэрэгсэл буюу навигацийн системийн үндэс суурь юм.



Өөрөөр хэлбэл хэл нь улс, хот, аж үйлдвэр, брэндийн соёлоос үл хамааран соёлын толь болдог.

Др. Сигмунд Фрейдийн хэлсэнээр:

---

**“Үг болон ид шид нь нэг л зүйл, өнөөдөр ч аливаа нэг үг ид шидийн гэмээр хүчийг агуулж байна”.**

---

Зөв үгс нь аливаа зүйлийг хөдөлгөх буюу эхлүүлэх, аюултай эсвэл найдваргүй байдлыг бууруулах, нийгмийн эв нэгдлийг нэмэгдүүлэх, тайван байдлыг бий болгох, тэр бүү хэл эдийн засгийг ч өсгөх чадвартай. Тухайн цаг мөчид хэчнээн тодорхойгүй байсан ч хямрал бүхэн түр зуурынх байдаг. Богино хугацаанд зөв хийсэн зүйл нь урт хугацаанд сайнаар нөлөөлнө. Тиймээс богино хугацааны бодит байдалд гацахын оронд том дүр зургийг харах нь чухал юм.

**COVID-19** нь бид бүгдийг урьд өмнө хэзээ ч байгаагүй хямралын тухай мэдлэгтэй болголоо. Асуудал болон бусад сул талыг ярихын оронд зорилгодоо чиглэсэн удирдагчид өөрийн давуу тал, боломж, шийдэл дээр анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг. Тэд бодит нөхцөлийг хурдан олж харан хямралын өмнө цаг гаргадаггүй байсан зүйлдээ цаг хугацаагаа зарцуулж байна.

Зорилгод чиглэсэн хүмүүс, байгууллагууд хямралтай үеийг өөрсдийн давуу талыг бэхжүүлэх чухал үе буюу:

- бүтээлч байх боломж
- дахин эсвэл бүр шинээр хийх боломж
- байгууллагадаа хөрөнгө оруулах боломж
- өөрийн дүр төрх, брэндэд хөрөнгө оруулах боломж
- хувь хүний хөгжил дэвшилд хөрөнгө оруулах боломж хэмээн харцгааж байна.

Бусад хүмүүс бэрхшээлийг олж хардаг бол амжилттай яваа хүмүүс бэрхшээлээс боломжийг олж хардаг бөгөөд хамгийн чухал нь тэрхүү боломжийг хэрхэн ашиглахад анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг.

Хамгийн сайн хямралын менежмент нь хариуцлага, санаачилгад суурилсан хүчтэй удирдлага юм. Тиймээс бодит, зорилгод чиглэсэн сэтгэлгээг хамгийн гол тулах цэгээ болгох нь ялангуяа энэ цаг үед хамгийн зүйтэй.



## БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМЛЭГ



ВРN-ийн  
Хөтөлбөрийн  
удирдагч:

О.Эрдэнэсүрэн



### Livestream Reinhard

2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахал газар авч улс орны төдийгүй дэлхийн эдийн засгийг сөхрүүлсэн жил болж өнгөрлөө.

Хүндхэн сорилттой нүүр тулсан дотоодын үйлдвэрлэгчид маань хямралыг хэрхэн боломж болгох талаар Швейцарын бизнес эрхлэгчдийн туршлагаас хуваалцан өөрсдийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хэрэгжүүлэхийг хүссэн билээ.

Бизнес эрхлэгчдийн нийгэмлэгийн зүгээс Швейцарын бизнес эрхлэгч **Alexander Reinhard**-тай “Хямралын үеийн оновчтой удирдлага” сэдвээр шууд ярилцлагыг зохион байгуулсан.

**Reinhard** ХК нь **1912** оноос өнөөг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд өнөөдөр **4** дахь үедээ **Alexander Reinhard**-ийн удирдлага дор ажиллаж буй гэр бүлийн компани юм.

Тэд зөвхөн бүс нутгийн буюу Берн муж орчмын үйлдвэрлэгчдийн **100%** байгалийн гаралтай түүхий эд материалаар бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж хэрэглэгчдэдээ хүргэдгээрээ бусад талх нарийн боов үйлдвэрлэгчдээс ялгаатай юм.

Ярилцлагын үеэр бизнес эрхлэгчид маань тулгамдаж буй асуудлаа нээлттэй ярилцаж санал бодлоо солилцсон нь хямралын үед тэдэнд урам зориг өгсөн, цаг үеэ олсон ярилцлага болж чадсан.







**Reinhard** ХК-ийн хувьд энэхүү хямралын үед “нөхөрсөг хамтын ажиллагаа”- г эхлүүлэн өөрийн өрсөлдөгч болох **Glatz** талх, нарийн боов үйлдвэрлэгчтэй хамтран ажиллаж бүтээгдэхүүнээ нэг дэлгүүрээр борлуулж байгаа нь ярилцлагад оролцогчдын анхаарлыг их татаж байсан юм. Тэд өрсөлдөгчид хэдий ч хүнд хэцүү үеийг хамтран эв нэгдэлтэйгээр даван туулах нь илүү үр дүнтэйг олж харснаар ажлын байр цомхотголгүйгээр үйлдвэрлэлээ тогтвортой явуулах гарцыг олсон юм. Энэхүү “нөхөрсөг хамтын ажиллагаа” нь хэрэглэгч рүүгээ илүү чиглэж хатуу хөл хорионы үед тэд нэг газраас хэрэгцээт бүтээгдэхүүнээ худалдан авах боломжийг олгож байгаа юм.

Мөн түүнчлэн хямралын үед компанийн удирдлагын зүгээс ажилтнуудаа үнэн зөв, бодит мэдээллээр ханган, ямар ч бэрхшээл саад тулгарсан тайван байж оновчтой шийдвэр гаргахын чухлыг онцолж байсан.

Энэ цар тахлаас үүдэн гарсан эдийн засгийн хямрал хэр удаан үргэлжлэхийг хэлж мэдэхгүй ч хамгийн багадаа л гэхэд **5** жил үргэлжлэх нь дамжиггүй байна. Тиймээс үйлдвэрлэгчид бид өдөр ирэх тутам хурдтай хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хурдан мэдэрч, түүнд нь нийцүүлэн бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж бие биеэ дэмжин ажиллах нь бидний сорилт болоод байна.

Ирж буй шинэ ондоо **ВРN** нийгэмлэгийн зүгээс бизнес эрхлэгчид хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж, шинэ содон, үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэн ажиллах болно.



## ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭГДЭЛ



Хөтөлбөрийн оролцогч  
“Персон” Эмэгтэйчүүдийн  
эмнэлгийн захирал

### Л.Удвал

**ВРН-ийн 2020 оны 10-р сарын 29-30-ны хооронд “Цагийн менежмент” сургалтад оролцлоо. Online-р оролцоход бэрхшээл байсангүй. Эрдэнэсүрэн маань маш сайн ойлгомжтой орчуулан тайлбарлаж өглөө. Миний хувьд цагийн менежментийн сургалт амьдралыг маань өөрчлөх шинэ дэвшил, шинэ санаа хөглөсөн сайхан сургалт боллоо. Шинэ оролцогчдоо, ВРН-ийн хамт олондоо мөн цагийн зөрүү үл харгалзан бидэнд цагаа зарцуулсан Маркус Эппер танд баярлалаа. Хойшид олон сайхан сургалт зохион байгуулаарай.**

.....



Хөтөлбөрийн оролцогч  
“Цэцэг Трейд” ХХК-ийн  
захирал

### Б.Цоморлог

Цагийн менежмент сургалтыг хүлээж байсны дагуу үр дүнтэй сайхан боллоо. Хэрэгжүүлж болохуйц олон зүйлсийг мэдэж авлаа. Онлайн-аар Маркус багш, зөвлөх маань шөнө дунд /тэндхийн цагаар/ бидэнтэй холбогдон яг хамт байгаа юм шиг үр дүнтэй зааж чадлаа. Мөн Эрдэнэсүрэн зөвлөх маань эрч хүчтэйгээр орчуулж өгч байгаад баярлалаа. Сургалт их өгөөжтэй сайхан байлаа. Өөрийн хийдэг байсан төлөвлөлтөө сайжруулан хийх боломж өгсөнд баярлалаа. Цаг төлөвлөлтийн дэвтэр маш их таалагдлаа. Энэ сургалтыг жаахан эрт мэдэж хамрагдсан бол их зүгээр байсан байна. ВРН-с зохион байгуулагддаг сургалтууд маш өгөөжтэй, их үр дүнтэй болдогт сэтгэл хангалуун байдаг шүү. Манай байгууллагын олон ажиллагсад танай байгууллагын сургалтад сууж мэргэжил чадвараа дээшлүүлж байсан их талархаж явдаг шүү. Цаашид олон сургалтад тасралтгүй хамрагдан, зөвлөгөө авах сонирхолтой байгаа шүү. Сургалт бүрээс үргэлж хэрэгтэй зүйлсийг сурч мэдэж авдаг. Баярлалаа.





Хөтөлбөрийн оролцогч “Жаргал” Чих хамар хоолойн эмнэлгийн захирал



### Э.Оюунчимэг

“Цагийн менежмент”-ийн 2 өдрийн сургалтад сууж маш их зүйлийг сурч мэдлээ. Цаашдаа сурсан зүйлээ ашиглаж илүү сайн сайхныг бүтээн ажиллах урам зоригтой боллоо. Энэхүү сургалтыг зохион байгуулж байгаа BPN-ийн хамт олон, Маркус Эпперт их баярлалаа. Хэдийгээр онлайн байгаа боловч энэ ямар нэгэн асуудал, хүндрэл болохгүй байгаа нь сайхан санагдлаа. Та бүхэндээ цаашдын ажилд нь өндөр амжилт хүсье.



“Classic Photo Studio”

### Б.Нансалмаа

BPN-ийн зүгээс зохион байгуулсан цагийн менежмент 2 өдрийн сургалтад анх удаа хамрагдаж суралцлаа. Сургалтын хувьд маш сэтгэл өндөр байна. Мэдэхгүй байсан маш олон зүйлээ мэдэж авлаа. Цаг хугацаа ямар их үнэ цэнтэй, эргэж давтагдашгүй гэдгийг ойлголоо. Үлдэж буй амьдралдаа маш идэвхтэй зорилгоо улам томруулж эрч хүчтэй амьдрахыг ойлголоо. Сурсан мэдсэн бүхнээ компани ажиллагсдаа хэлж хэрэгжүүлнэ гэж бодож байна. Маш найрсаг хамт олон бидэнд цаг заваа зарцуулсанд баярлалаа. Танай хамт олонд ажлын улам өндөр амжилт хүсье. Эрүүл энх байгаарай.



# БАЯАРЛДАГАА



**«BPN-нд хандсан явдал надад  
олон өөрчлөлтүүдийг шинээр  
хийх алсын хараа минь  
болсон.»**

**“Өөдлөн дэвжих” ХХК-ийн захирал:**

**Г.Цацралтуяа**

